

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2026.07.27

Capital Economics	8,000
Deutsche Bank	8,000
Wells Fargo	7,800
Morgan Stanley	7,800
Goldman Sachs	7,750
RBC	7,750
JPMorgan	7,500
HSBC	7,500
UBS	7,500
Barclays	7,400
Bank of America	7,100
Дундаж	7,645





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2026.07.20-07.26

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд өнгөрсөн долоо хоногийг ихэнхдээ уналттай дуусгалаа. Хиймэл оюунд чиглэсэн асар их хөрөнгө оруулалт бодит өгөөжөө хэр хурдан өгөх вэ гэсэн эргэлзээ, мөн газрын тосны үнийн огцом өсөлт хөрөнгө оруулагчдын хүлээлтэд сөргөөр нөлөөлөв.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛ ТАЙЛАН РУУ ТӨВЛӨРЛӨӨ.

Эдийн засгийн чухал мэдээлэл цөөн гарсан энэ долоо хоногт хөрөнгө оруулагчдын анхаарал компаниудын тайлан руу төвлөрөв. S&P 500 индексийн бүрэлдэхүүнд багтдаг 86 компани улирлын тайлангаа танилцуулсан бөгөөд Alphabet болон Tesla-ийн хувьцаа тайлангийн дараа буурлаа. Хөрөнгө оруулагчид эдгээр компанийн өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулалтын зардал болон сул мөнгөн урсгалд голчлон анхаарсан байна. Энэ нь томоохон технологийн компаниуд AI салбарт хэт их хөрөнгө зарцуулж байгаа эсэх талаарх болгоомжлолыг нэмэгдүүлж, технологийн хувьцаанд нийтэд нь дарамт үзүүлэв.

ДАЙНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮРГЭЛЖИЛСЭН ХЭВЭЭР БАЙНА.

Үүний зэрэгцээ Ойрх Дорнод дахь мөргөлдөөн үргэлжилж, гал зогсоох хэлэлцээ ахицгүй байгаа шинж тэмдэг илэрсэн нь зах зээлийн анхаарлыг татлаа. Геополитикийн эрсдэл нэмэгдсэнээр газрын тосны үнэ огцом өсөж, эрчим хүчний компаниудын хувьцааг дэмжсэн ч аялал жуулчлал, тээвэр болон хэрэглээний салбаруудад дарамт болсон байна. Газрын тосны үнийн өсөлт инфляц дахин эрчимжих болгоомжлолыг нэмэгдүүлж, АНУ-ын Засгийн газрын бондын өгөөжийг өсгөсөн бөгөөд Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ нэмэгдүүлж болзошгүй гэсэн зах зээлийн хүлээлтийг ч нэмэгдүүлжээ.

ХНС-ИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛД ӨӨРЧЛӨЛТ ОРЖ МАГАДГҮЙ.

Fed-ийн улирал тутмын эдийн засгийн төсөөллийн (SEP) тайлангаас дундаж төсөөллийг хасах өөрчлөлт хийх магадлалтай. Ингэснээр зах зээл нэг тоонд хэт төвлөрөхөөс сэргийлж, Fed-ийн бодлогыг илүү бодитой ойлгох боломжтой болох ч ил тод байдал үндсэндээ хэвээр хадгалагдана.


- Fed цаашид хувийн хэвшлийн мэдээллийн сангуудыг илүү өргөн ашиглах төлөвтэй байна. Гэхдээ эдгээр мэдээлэл нь албан ёсны статистикийг бүрэн орлохгүй.
- Кевин Уорш хиймэл оюун ухаан бүтээмжийг огцом өсгөж, урт хугацаанд инфляцыг бууруулна гэж үздэг.
- 2%-ийн инфляцын зорилт өөрчлөгдөхгүй.

7-р сарын 29-30 –нд шилжих шөнө 02:00 цагаас ХНС-ийн ээлжит бодлогын хүүгийн хурал болохоор хүлээгдэж байна.




АНУ-ын хувьцааны техник шинжилгээ

NASDAQ: NVDA 23%-ИЙН ӨСӨЛТИЙН БОЛОМЖ БИЙ – ЗОРИЛТ: 254\$



NASDAQ: PYPL 35%-ИЙН ӨСӨЛТИЙН БОЛОМЖ БИЙ – ДУНД ХУГАЦААНД





Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2026.07.20–07.26

Долоо хоногийн эхээр төрөөс зах зээлийг дэмжих худалдан авалтууд, ялангуяа хагас дамжуулагч болон технологийн хувьцаанд чиглэсэн хөрөнгө оруулалт өсөлтийг дэмжжээ. Харин долоо хоногийн сүүлээр AI салбарын өндөр үнэлгээний талаарх болгоомжлол болон Ойрх Дорнодын хурцадмал байдлаас шалтгаалан газрын тосны үнэ өссөнөөр өсөлтийн тодорхой хэсгийг буцаан алдсан байна.

ТӨРИЙН ДЭМЖЛЭГЭЭР ЗАХ ЗЭЭЛ НЬ ӨСӨВ

Төрийн өмчит хөрөнгө оруулалтын байгууллагууд нийт 60 тэрбум юаниар хувьцаа худалдан авч, зах зээлийг дэмжжээ. Үүний зэрэгцээ Хятадын Үнэт Цаасны Зохицуулах Хорооны дарга зах зээлийн тогтвортой байдлыг хангахын тулд бүх арга хэмжээг авна гэдгээ мэдэгдсэн бол томоохон даатгалын компаниуд урт хугацааны хувьцааны хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхээр болсон байна.

Hang Seng индекс



HKEX:9988



СХМТ-н хувьцаанд зах зээл төвлөрч байна.

Хятадын санах ойн чип үйлдвэрлэгч Changxin Technology Group (CXMT)-ийн хувьцаа өнөөдөр Шанхайн технологийн компаниуд төвлөрсөн STAR Market бирж дээр анхны арилжаагаа хийж, ойролцоогоор 470%-иар өслөө. Тус компани IPO-оо нэгж хувьцааг 8.66 юань-аар үнэлэн нийт 57.92 тэрбум юань (8.6 тэрбум ам.доллар) татан төвлөрүүлсэн бөгөөд арилжааны эхэнд хувьцааны ханш 49 юань хүрч огцом өссөн байна.

IPO танилцуулгын мэдээллээр, 2025 оны байдлаар CXMT дэлхийн DRAM зах зээлийн 7.67%-ийг эзэлж байсан. DRAM нь ухаалаг гар утас, компьютер, дата төвийн сервер зэрэг олон төрлийн электрон төхөөрөмжид ашиглагддаг үндсэн санах ойн чип юм.

Мөн энэ сарын эхээр Apple компани Хятадын зах зээлд борлуулах төхөөрөмжүүддээ ашиглах зорилгоор CXMT-ийн DRAM чипийг туршиж эхэлсэн гэх мэдээлэл гарснаар компанид хөрөнгө оруулагчдын анхаарал улам нэмэгдсэн байна.



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

EARNINGS WHISPERS

Most Anticipated Earnings Releases
for the week beginning
July 20, 2026

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
amc AMC DPZ DPZ RYANAIR RYAAY SmartBank SBK	CROWN CCK BOK FINANCIAL BOKF Steel Dynamics, Inc. STLD Berkley WRB ZIONS BANCORPORATION ZION Calix CALX WATSON GROUP HOLDINGS, INC. WASH WINTRUST WTRF AGNC AGNC MONARCH MCR	HALLIBURTON HAL VICOR VICR ally ALLY D R HORTON DHI DANAHER DHR charles SCHWAB SCHW gm GM 3M MMM valmont VMI MSCI MSCI	Alaska AIRLINES ALK EAST WEST BANK EWBC ANNALY NLY AAR AIR EQT EQT RANGE RESOURCES RRR Northquest Bancorp, Inc. NFB Western Alliance Bancorporation WAL PEGA PEGA HWC HWC	GE VERNOVA GEV AT&T T PHILIP MORRIS INTERNATIONAL PM TRAVEL+LEISURE TNL Wabtec CORPORATION WAB TE connectivity TEL PulteGroup PHM iridium IRDM Moody's MCO 1First Bank FBP	TESLA TSLA Alphabet GOOGL servicenow NOW IBM IBM TEXAS INSTRUMENTS TXN KINDER MORGAN KMI TEXAS CAPITAL BANK TCBI USL GREEN REALTY CORP SLG CROWN CASTLE CCI CSX CSX	NOKIA NOK CLIFFS CLF American Airlines AAL Huntington HBAN Fidelity Investments FCX ST STM The Blackstone Group BX CEMEX CX LOCKHEED MARTIN LMT TRACTOR SUPPLY CO. TSKO	intel INTC MxL MEL DECKERS DECK Newmont NEM Columbia Bank COLB BOYD BYD sallie mae SLM BOSTON BEER co. SAM RingCentral RNG jaks JAKK	verizon VZ Charter COMMUNICATIONS CHTR AMERICAN EXPRESS AAP NEXTERA ENERGY NEE CN CNI Booz Allen Hamilton BAH Lamb Weston LW slb SLB HCA Healthcare HCA CENTRAL PACIFIC FINANCIAL CPF	

http://eps.sh/call

© 2026 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

EARNINGS WHISPERS

Most Anticipated Earnings Releases
for the week beginning
July 27, 2026

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
AstraZeneca AZN Baker Hughes BKR Bank of Hawaii BOH ALLIANCE ARLP HBT Financial HBT Coca-Cola FEMSA KOF PERFECT PERF Bank of Hope HOPE NOBLE NE Bank of Marin BMR	APPLIED DIGITAL APLD Navitas NVT Celestica CLS NUCOR NUE Rambus RMB element solutions ESI Amkor Technology AMKR UHS UHS cadence CDNS	PayPal PYPL BOEING BA Coca-Cola KO ups UPS CORNING GLW HF Sinclair DINO jetBlue JBLU COMMVAULT CVLT HUBBELL HUBB Incyte INCY	Bloomenergy BE SEAGATE STX ENPHASE ENPH KLA KLAC VISA V TERADYNE TER TILRAY TLRY avis budget group CAR Ford F The Cheesecake Factory CAKE	SoFi SOFI Boston Scientific BSX VERTIV VRT Amphenol APH flex FLEX GENERAC GNRC Humana HUM ADP ADP cognizant CTSH UMC UMC	Microsoft MSFT Meta META Robinhood HOOD arm ARM O'Reilly AUTO PARTS ONLY Qualcomm QCOM Lam Research LRCX CHIPOTLE CMG AGNICO EAGLE AEM FORTINET FTNT	mastercard MA Bristol Myers Squibb BMY Cigna CI Valero VLO BLUE OWL OWL QUANTA QNTA PWR FERRARI STELANTIS STLA Altria MO Baxter BAX	Apple AAPL amazon AMZN ROBLOX RBLX reddit RDDT AXT AXT MasTec MTZ DIAMONDROCK DRH RIVIAN RIVN SONY SONY HUNTSMAN HUN	ExxonMobil XOM Chevron CVX Cameco CCJ moderna MRNA AutoNation AN abbvie ABBV Dominion Energy D ARBOR ARB MAGNA MGA CHD CHD	

http://eps.sh/cal

© 2026 Earnings Whispers